

МАНДАЛ
даатгал

МАНДАЛ ДААТГАЛ ХК

Хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хурал

2021

ХУРЛЫН МАТЕРИАЛ | 2021.04.19

АГУУЛГА

Хурлын зар	4
Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа	5
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн	5
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол	6
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн	8
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг	9
Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан	10
Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт	14
Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт	17
Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэр	18
Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох	19
Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах	31
Компанийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах	32
Тогтоолын төсөл	33
Саналын хуудас	37
Итгэмжлэлийн загвар	51

ХУРЛЫН ЗАР

Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Ээлжит хурал” гэх) нь 2021 оны 04-р сарын 19-ний өдрийн 17 цаг 00 минутад Компанийн албан ёсны Facebook хуудас ашиглан цахим хэлбэрээр хийх тул Хувьцаа эзэмшигч та бүхэн Фэйсбүүкийн <https://www.facebook.com/mandaldaatgal/> хаягаар хуралдаа оролцоорой.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шууд дамжуулалтыг Ай Си Си Таур оффисын 2 давхрын хурлын танхимаас шууд дамжуулна.

Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг **stock.mandal.mn** сайтаар хэрэгжүүлнэ.

Ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн, шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
5. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үүнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
6. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах;
7. Компанийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв батлах;

Ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр нь **2021 оны 04-р сарын 01-ны өдөр** (“Бүртгэлийн өдөр”) байна.

Бүртгэлийн өдрөөр тасалбар болгосон хувьцаа эзэмшигчийн нэрсийн жагсаалтад орсон хувьцаа эзэмшигч нь Ээлжит хуралд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцох эрхтэй ба Паркплэйс Билдинг, Чингисийн өргөн чөлөө – 24, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Улаанбаатар 14241 хаягаар, тооллогын комиссоор дамжуулан Ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд өгөх саналаа саналын хуудсаар урьдчилан өгөх боломжтой.

Хэрэв хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийг төлөөлөн хуралд оролцогч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар, гүйцэтгэх захирал биш бол хуулийн этгээдээс олгосон хүчин төгөлдөр итгэмжлэлийг заавал авчрах шаардлагатай.

Саналын хуудсаар авах сүүлийн хугацаа **2021 оны 04-р сарын 19-ний өдрийн 17 цаг 00 минут** байна.

Ээлжит хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын дараах хаягаар холбогдон авна уу.

№	Комиссын гишүүдийн нэрс	Утасны дугаар	Шуудангийн хаяг
1	Б.Энхтүвшин	7577-3000	enkhtuvshin@mandal.mn
2	З.Одмаа	7577-3000	odmaa@mandal.mn

Ажиллах цагийн хуваарь: Ажлын өдрүүдэд 9⁰⁰–17⁰⁰ цагийн хооронд ажиллана.

Компанийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө 24, Сөүл рестораны баруун талд Паркплэйс Оффис, 3 давхарт.

Имэйл: enkhtuvshin@mandal.mn

Утас: 75773000

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТАНИЛЦАЖ БОЛОХ БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ, УГ БИЧИГ БАРИМТТАЙ ТАНИЛЦАЖ БОЛОХ ГАЗАР, ХУГАЦАА

Хувьцаа эзэмшигчийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчид нь 2021 оны 03-р сарын 12-ны өдрөөс эхлэн 04-р сарын 19-ний өдрийг хүртэл ажлын өдрүүдийн 09:00 – 17:00 цагийн хооронд Мандал Даатгал ХК-ийн оффист болон өөрийн харилцаж буй брокер дилерийн компаниуд дээрээ очиж дараах баримт бичгүүдтэй танилцах боломжтой. Үүнд:

Хувьцаа эзэмшигчид нь дор дурдсан бичиг баримттай танилцаж болно. Үүнд:

1. Хурлын зар;
2. Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалт, уг бичиг баримттай танилцаж болох газар, хугацаа;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүн;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын бүрэлдэхүүн;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
7. Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан;
8. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлт;
9. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт;
10. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэр;
11. Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшсэн хүмүүсийн танилцуулга;
12. Компанийн дүрмийн нэмэлт өөрчлөлт;
13. Компанийн нэгдсэн сонирхолтой этгээд, түүний эзэмшлийн хувьцааны тоо;
14. Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин, урамшуулал;
15. Компанийн ТУЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны зардлын төсөв;
16. Тогтоолын төсөл;
17. Саналын хуудас;
18. Итгэмжлэлийн загвар.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Зохион байгуулах комиссын дарга:

Б.Энхтүвшин /ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/

Зохион байгуулах комиссын гишүүд:

З.Одмаа /Маркетинг Бизнес Хөгжлийн Газрын захирал/
Г.Баярцэцэг /Ерөнхий нягтлан бодогч/
Д.Бавуугарьд /Мэдээллийн технологи хариуцсан менежер/
У.Номгон /Оффис менежер/

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 21/004

Улаанбаатар хот

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх хэсэг, 60 дугаар зүйл, 71 дүгээр зүйлийн 71.3 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2 дэх хэсэг, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Мандал Даатгал ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм (цаашид “Дүрэм” гэх)-ийн 8-р зүйлийн 8.13.3 болон 8.13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2021 оны 04 сарын 19-ний өдрийн 17:00 цагаас компанийн албан ёсны фэйсбүүк <https://www.facebook.com/mandaldaatgal/> хаягаар дамжуулан цахим хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ирц, санал хураалт, асуултыг www.stock.mandal.mn сайтаар хэрэгжүүлсүгэй.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 - 3.1. Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
 - 3.2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
 - 3.3. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах;
 - 3.4. Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах;
 - 3.5. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, үүнтэй холбогдуулан Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
 - 3.6. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах болон
 - 3.7. ТУЗ-ийн 2021 үйл ажиллагааны зардлын төсөв батлах.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийг 2021 оны 04 сарын 01-ний өдрөөр тасалбар болгон Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр хийлгэсүгэй.
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг энэхүү тогтоолын **Хавсралт №1**-ээр баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг 2021 оны 03 сарын 17-ны өдөр, 2021 оны 04 сарын 01-ний өдрүүдэд өдөр тутмын сонин болон Компанийн www.mandal.mn болон, Монголын Хөрөнгийн Биржийн www.mse.mn цахим хуудсаар тус тус дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлсүгэй.
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой хувьцаа эзэмшигчдийн танилцвал зохих мэдээлэл, баримт бичгийн жагсаалтыг **Хавсралт №2**-оор баталсугай.

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Паркплэйс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292 Улаанбаатар 15160

☎ (976) 7575 2000
✉ info@mandal.mn
🌐 www.mandal.mn

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ



2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 21004

Улаанбаатар хот

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн шийдвэрлэх асуудлаар өгөх саналыг саналын хуудсаар авах бөгөөд саналын хуудасны агуулга болон загварыг **Хавсралт №3**-аар баталсугай. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцоогүй боловч саналын хуудсаар дамжуулан урьдчилан саналаа ирүүлсэн хувьцаа эзэмшигчийг хуралд оролцсон гэж үзэх бөгөөд уг саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа нь 2021 оны 04-р сарын 19-ний өдрийн 17 цаг 00 минут хүртэл байна.
8. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан 2021 оны 03-р сарын 13-ны өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржид Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл, энэхүү тогтоолын Хавсралт №1 болон Хавсралт №2 дахь мэдээлэл болон Компанийн тухай хуулийн 80.11-т заасан мэдээллийн хамт хүргүүлсүгэй.
9. Энэхүү тогтоол батлагдан гарсантай холбогдуулан Хавсралт №2-оор баталсан мэдээлэл, баримт бичгийн төслийг эзвэлмэл болон цахим хэлбэрээр 2021 оны 03-р сарын 17-ны өдөр хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар ТУЗ-ийн дарга Өлзийбаяр овогтой Ганзоригийг томилсугай.
11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар батлах тогтоолын төслийг **Хавсралт №4**-р баталсугай.
12. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг **Хавсралт №5**-р баталсугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох төлөөлөгчийн итгэмжлэлийн загварыг **Хавсралт №6**-р баталсугай.
14. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Балдан овогтой Энхтүвшинд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Паркплэйс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292 Улаанбаатар 15160

(976) 7575 2000
info@mandal.mn
www.mandal.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН



2021 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 21/005

Улаанбаатар хот

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Тооллогын комисс томилох тухай

Мандал Даатгал ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдахтай холбогдон Тооллогын комиссыг томилох тухай асуудлыг хэлэлцэн, Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1 дэх хэсэг, Компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.13.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Мандал Даатгал ХК-ийн 2021 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

Комиссын дарга: З.Цэндсүрэн /Стратеги төлөвлөлт хариуцсан менежер/
Гишүүд: А.Ундрал /Ахлах санхүүгийн шинжээч/
Б.Баяржаргал /Санхүүгийн шинжээч/
Л.Насанжаргал /Санхүүгийн шинжээч/

2. Тооллогын комисс (З.Цэндсүрэн)-д дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг даалгасугай.
Үүнд:

- a) Хурлын ирцийг бүртгэж хурлын даргад мэдээлэх;
- b) Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр саналын эрхтэй байх хувьцааны тоо, төрлийг тодорхойлох;
- c) Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, санал өгөх эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдон гарах аливаа асуултанд тайлбар өгөх;
- d) Санал өгөх журмыг тайлбарлах, хувьцаа эзэмшигчдийн санал өгөх эрхийг хангах;
- e) Саналын хуудсыг тоолж, саналын хуудсыг хүлээн авах бөгөөд санал хураалтын дүнгийн тухай тэмдэглэл хөтлөх;
- f) Саналын дүнг нэгтгэн, санал хураалтын дүнгийн тухай тооллогын комиссын шийдвэрийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулах.
- g) Саналын хуудсыг компанийн архивд хадгалуулахаар шилжүүлэх.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

МАНДАЛ ДААТГАЛ ХК | Регистрийн дугаар: 5473489
Хаяг: Паркплэйс Оффис, Чингисийн өргөн чөлөө-24, Сүхбаатар дүүрэг,
1-р хороо, Улаанбаатар хот 14241, Монгол улс
Шуудангийн хаяг: Ш/х-2772/2292 Улаанбаатар 15160

☎ (976) 7575 2000
✉ info@mandal.mn
🌐 www.mandal.mn

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ


Хугацаа	Хөтөлбөр	Хариуцагч
17:00 - 17:10	Хурлын ирц бүртгэх /Илтгэл/	Тооллогын комисс
17:10 - 17:20	Хурлын ирцийг мэдээлэх	Тооллогын комисс
17:20 - 17:30	Хурлын дэгийг танилцуулна	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
17:30 - 17:40	Хурлын дарга хурлыг нээж үг хэлнэ	Хурлын дарга - Ө.Ганзориг
17:40 - 18:00	Компанийн 2020 оны бизнесийн үйл ажиллагааны тайлан	Гүйцэтгэх захирал - Б.Жавхлан
18:00 - 18:10	Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг танилцуулах	Гүйцэтгэх захирал - Б.Жавхлан
18:10 - 18:15	Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах	Хурлын дарга - Ө.Ганзориг
18:15 - 18:20	Компанийн ногдол ашиг тараах эсэх талаарх ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах	Хурлын дарга - Ө.Ганзориг
18:20 - 18:35	Компанийн ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
18:35 - 18:40	Компанийн ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлын төсөв танилцуулах	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
18:40 - 19:00	Санал хураалт	Тооллогын комисс
19:00 - 19:20	Хурлын завсарлага, санал тоолох	Тооллогын комисс
19:20 - 19:30	Санал хураалтын дүнг танилцуулах	Тооллогын комисс
19:30 - 19:40	Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулах	Тооллогын комисс
19:40 - 19:50	Хурлын дарга хурлыг хааж үг хэлнэ	Хурлын дарга - Ө.Ганзориг

МАНДАЛ ДААТГАЛ ХК-ИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН


ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2020 оны байдлаар 83,480 хувь хүн болон албан байгууллагын эрсдэлийг даатгаж, нийт 33.4 тэрбум төгрөгийн хураамжийн орлоготой ажиллалаа. Энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15%-аар өссөн үзүүлэлт бөгөөд компанийн борлуулалтын төлөвлөгөө 89%-ийн биелэлттэй байна.

Даатгуулагчдын тоо



Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг



Хураамжийн орлогын 90 хувийг голлох 5 даатгалын хэлбэр эзэлж байгаа бөгөөд эдгээр 5 бүтээгдэхүүний багц харьцангуй жигд байна.

Хураамжийн орлогын бүтэц, бүтээгдэхүүнээр



Тээврийн хэрэгслийн даатгал	29%
Эрүүл мэндийн даатгал	28%
Хөрөнгийн даатгал	17%
Гэнэтийн ослын даатгал	10%
ЖХАЖД	6%
Бусад	10%

Иргэдийн даатгал/Байгууллагын
даатгалын харьцаа


29/71

Цэвэр хураамж/Давхар
даатгалын харьцаа


52/48

2020 онд нийт 13,604 даатгуулагчид 7.9 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг олгожээ. Нийт нөхөн төлбөрийн зардал өнгөрсөн оноос 45%-аар өсчээ.


Нөхөн төлбөр авсан даатгуулагчийн тоо



Нөхөн төлбөр, тэрбум төгрөг



Нөхөн төлбөрийн бүтэц, бүтээгдэхүүнээр




Тээврийн хэрэгслийн даатгал	37%
Эрүүл мэндийн даатгал	34%
Хөрөнгийн даатгал	16%
ЖХАЖД	6%
Хариуцлагын даатгал	3%
Гэнэтийн ослын даатгал	3%
Бусад	1%


САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

Нийт хөрөнгийн хэмжээ 55.2 тэрбум төгрөгт хүрч өссөний 33.6 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгө эзэлж байна. Энэ нь компанийн хөрөнгө оруулалтын орлого нэмэгдэж, ашигт ажиллагааг дээшлүүлэх суурь болж байна.


Нийт хөрөнгө, тэрбум төгрөг




Мөнгөн хөрөнгө, тэрбум төгрөг




Нийт хураамжийн орлого, тэрбум төгрөг



Цэвэр ашиг, тэрбум төгрөг



Нийт болон өөрийн хөрөнгийн өгөөж



ХУВЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТ

2020 онд Мандал Даатгал ХК нь цэвэр ашгаасаа 2.5 тэрбум төгрөгийн ногдол ашиг тараасан. Нийт 1.1 тэрбум төгрөгийн арилжаа явагдсан байна.



Өдрийн дундаж
арилжааны дүн
4.3 сая

EPS харьцаа
7.3

P/E харьцаа
6.6

ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



"ГРАНТ ТОРНТОН АУДИТ" ХХК
Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Санхүүгийн хураангуй тайлангийн талаарх Хараат бус аудиторын дүгнэлт

"Мандал даатгал" ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд:

Дүгнэлт

Бид "Мандал даатгал" ХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон жилийн орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг (цаашид хамтад нь "хураангуй санхүүгийн тайлан" гэх) 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудитын тайлангаас хураангуйлан авч бэлтгэсэн болно.

Бидний дүгнэлтээр, энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

Хураангуй санхүүгийн тайлан

Энэхүү хураангуй санхүүгийн тайлан нь Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын үзэмжтэй тушаалаар батлагдсан "Даатгалын компаниудад мөрдөгдөн Санхүүгийн тайлангийн мэтг, тодруулга"-д шаардсан бусад тайлбар тодруулгуудыг иж бүрэн агуулаагүй тул "Мандал даатгал" ХК-ийн аудитын тайланг бүрэн дүүрэн орлохгүй болно.

Энэхүү хураангуй санхүүгийн тайланд 2020 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн манай аудитын тайлангийн дүгнэлттэй ижил дүгнэлт илэрхийлсэн бөгөөд эдгээр санхүүгийн тайлан болон хураангуй санхүүгийн тайланд манай аудитын тайлангийн өдрөөс хойш балансын дараах үйл явдлын нөлөөллийг тусгаагүй.

Аудитлагдсан санхүүгийн тайлан ба түүнд өгсөн бидний дүгнэлт

Бид аудитлагдсан санхүүгийн тайланд эерэг дүгнэлт өгсөн ба уг дүгнэлтэд доорх асуудал багтсан.


- Аудитын гол асуудал - Аудитын гол асуудал нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад бидний мэргэжлийн үнэлэмжээр хамгийн их нөлөөтэй асуудал болох "Нөөц сангийн тооцоолол" байсан.

Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайд болон Санхүүгийн зохицуулах хорооны даргын баталсан холбогдох дүрэм, журмын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах үүрэгтэй.

Аудиторын үүрэг хариуцлага

Бидний үүрэг хариуцлага бол Аудитын олон улсын стандарт, Монгол улсын "Аудитын тухай" хуулийн дагуу хийсэн аудитдаа үндэслэн энэхүү санхүүгийн тайлангуудын талаар хараат бус дүгнэлт өгөх явдал юм.



Далай тауэр 9 давхар, ЮНЕСКО
гудамж, Сүхбаатар дүүрэг, 1-р
хороо, Улаанбаатар 14230,
Монгол улс
Т + 976 70 110744
+ 976 70 110799

Dalai Tower, 9 fl, UNESCO street,
Sukhbaatar District-1, Ulaanbaatar
14230, Mongolia
T + 976 70 110744
+ 976 70 110799

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2019	2020
ХӨРӨНГӨ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	904,137	2,230,334
Даатгалын авлага	6,253,418	5,256,775
Бусад санхүүгийн хөрөнгө	618,472	376,269
Бусад санхүүгийн бус хөрөнгө	867,695	560,599
Хөрөнгө оруулалт	27,638,364	31,355,450
Даатгалын хөрөнгө	3,857,214	13,748,739
Үндсэн хөрөнгө	537,192	1,483,514
Биет бус хөрөнгө	69,519	144,057
НИЙТ ХӨРӨНГӨ	40,746,011	55,155,737
ӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ		
Даатгалын өглөг	1,850,517	2,913,586
Бусад санхүүгийн өр төлбөр	-	19,074
Бусад санхүүгийн бус өр төлбөр	738,085	1,776,045
Орлогд тооцоогүй хураамжийн нөөц	12,834,046	21,371,085
Нөхөн төлбөрийн нөөц сан	4,594,113	6,421,757
Нийт өр төлбөр	20,016,761	32,501,547
Эздийн өмч		
Хувьцаат капитал	6,243,016	6,243,016
Нэмж төлөгдсөн капитал	4,441,896	4,441,896
Дахин үнэлгээний нэмэгдэл	(71,096)	(147,148)
Хуримтлагдсан ашиг, алдагдал	10,115,434	12,116,426
Нийт эздийн өмч	20,729,250	22,654,190
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	40,746,011	55,155,737

ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

Мянган төгрөгөөр	2019	2020
Даатгалын үйл ажиллагаа		
Даатгалын хураамжийн орлого	28,927,212	33,224,744
Даатгалын хураамжийн буцаалт	(2,210,956)	(1,599,998)
Давхар даатгалын хураамжийн зардал	(10,842,392)	(15,220,697)
Даатгалын хураамжийн цэвэр орлого	15,873,864	16,404,049
ОТХНС-ийн өөрчлөлт	(281,307)	8,537,040
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	(267,079)	(9,140,559)
Орлогод тооцсон хураамж	16,422,250	17,007,568
Нийт нөхөн төлбөрийн зардал	5,422,537	7,862,275
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	674,283	640,962
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	384,427	57,144
Нөхөн төлбөрийн цэвэр зардал	4,363,827	7,164,169
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	1,683,438	985,026
НТНС-ийн ДД-д ногдох хэсгийн өөрчлөлт	415,132	(634,774)
УБХНС-ийн өөрчлөлт	(472,722)	842,618
Зардалд тооцсон нөхөн төлбөр	5,989,675	8,357,039
Даатгалын гэрээний зардал	(1,177,917)	(1,541,836)
Давхар даатгалын шимтгэлийн орлого	82,585	127,740
Хөрөнгө оруулалтын олз, гарз	3,734,284	4,788,912
Даатгалын үйл ажиллагааны ашиг	13,071,527	12,025,345
Хүү, эрхийн шимтгэлийн орлого	26,127	29,655
Бусад орлого	51,451	344,953
Ерөнхий ба удирдлагын зардал	(5,611,432)	(6,600,523)
Борлуулалт, маркетингийн зардал	(1,014,256)	(940,021)
Санхүүгийн зардал	0	(254,691)
Бусад зардал	(3,104)	(417,554)
Гадаад валютын ханшийн зөрүүний олз	14,956	824,660
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	366	0
Бусад алдагдал	(6,535,892)	(7,013,611)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	6,535,635	5,011,734
Орлогын татварын зардал	665,047	477,666
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	5,870,588	4,534,068

2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БОЛОН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ӨГӨХ ДҮГНЭЛТ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ө.ГАНЗОРИГ

Мандал Даатгал ХК-ийн эрхэм харицагч, хувьцаа эзэмшигч, хамтран ажиллагч та бүхэнд 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, 2020 оны зорилго зорилтуудын гүйцэтгэлийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн баталсан дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Мандал Даатгал ХК-ийн ТУЗ нь 2019 оны 12 сарын 19-ны өдрийн ТУЗ-ийн ээлжит хурлаар Мандал Даатгал ХК-ийн 2020 оны Бизнес төлөвлөгөөг хэлэлцсэн баталсан. ТУЗ-ийн баталсан 2020 оны Бизнес төлөвлөгөөний гол зорилго нь компани зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэх, Олон улсын үнэлгээний байгууллагаар үнэлгээ тогтоолгосон анхны компани болох, компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх байсан бөгөөд үүний хүрээнд үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, ажилтнуудын ур чадварын сайжруулах гэсэн гурван төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна.

2020 он хэдийгээр Корона вирусээс болж хөл хорио тогтоож, эдийн засгийн хувьд хүнд жил байсан боловч Мандал Даатгал ХК 2020 онд нийт 33,2 тэрбум төгрөгийн хураамжийн орлого олж, өмнөх оны мөн үеэс 15% өссөн, татварын дараах цэвэр ашиг 4.5 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 23% буурсан гүйцэтгэлтэй гарлаа.

Эдийн засгийн хямралтай байсан 2020 онд Мандал Даатгал ХК-ийн нөхөн төлбөр өмнөх оноос даруй 64 хувиар өсөж 7,2 тэрбум төгрөгт хүрсэн нь энэ хүнд хэцүү үед Мандал Даатгал ХК даатгуулагчдын өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа алдалгүй хүргэж байсан гэж үзэж байна.

Компанийн мөнгөн хөрөнгө 28,5 тэрбум төгрөгөөс 33,6 тэрбум төгрөг болж нэмэгдсэнээр хөрөнгө оруулалтын орлого өмнөх оноос 47 хувиар өсч 2020 онд хөрөнгө оруулалтаас 5.5 тэрбум төгрөгийн орлого олсон байна. Мөн нийт хөрөнгө 55.2 тэрбум төгрөг болж өмнөх оноос 36% өссөн үзүүлэлттэй байна.

Мөн Мандал Даатгал ХК нь 2020 онд олон улсын AM Best агентлагаас BB+ үнэлгээ авсан Монголын анхны компани болсон. Энэ үйл явдал нь Мандал Даатгал ХК-ийн хувьцаа эзэмшигч, харилцагчдын бидэнд итгэсэн итгэлийг бататгаж, бидний ажлын үр дүнг дүгнэсэн явдал болсон. 2020 он хэдийгээр хүнд хэцүү жил байсан боловч Мандал Даатгал ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн дүүрэн ашиглан ажилласан гэж ТУЗ-өөс дүгнэж байна.

2021 оны 03 дугаар сарын 10 өдөр

НОГДОЛ АШИГ ТАРААХ ТУХАЙ ШИЙДВЭР



2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 21/001

Улаанбаатар хот

МАНДАЛ ДААТГАЛ ХК-НИЙ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.5 дугаар зүйл, Мандал даатгал хувьцаат компанийн дүрмийн 8.14 дүгээр зүйлийг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Мандал даатгал ХК нь 2020 онд ашигтай ажилласныг үндэслэн 2020 оны цэвэр ашгийн дүнгээс нэгж хувьцаанд 3 /гурван/ төгрөг буюу нийт 1,872,904,800.00 /нэг тэр бум найман зуун далан хоёр сая ёсон зуун дөрвөн мянга найман зуун/ төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсүгэй.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрөөр тасалбар болгохоор тогтоосугай.
3. Энэхүү тогтоолын дагуу хуваарилах ногдол ашгийг 2021 оны 6 сарын 30-ны өдрийн дотор “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК дахь хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулах замаар олгосугай.
4. Энэхүү тогтоолын дагуу ногдол ашиг хуваарилсаны дараа Компани нь төлбөрийн чадвартай байх бөгөөд Компанийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа болохыг дурдсугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангах болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулах ажлыг гүйцэтгэх захирал Б.Жавхланд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ө. ГАНЗОРИГ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

1. **Өлзийбаяр овогтой Ганзориг**
2. **Шаравпэлжээ овогтой Гантуяа**
3. **Очирпүрэв овогтой Ганжолоо**
4. **Отгон овогтой Мөнхжаргал**
5. **Лувсанжамба овогтой Ганзоригт**
6. **Батсайхан овогтой Жавхлан**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Өлзийбаяр ГАНЗОРИГ

Төрсөн он: **1981**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Маастрихтын Менежментийн Их Сургууль	Нидерланд	2006	2007	Санхүүгийн удирдлага
2	Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль	Улаанбаатар	2004	2006	Нягтлан бодох бүртгэл

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	2013/04	2013/04	Компанийн засаглал

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Мандал Даатгал ХК	ТУЗ-ийн дарга	2018 - одоо
2	Голомт Банк	Гүйцэтгэх захирал	2016 - 2018
3	Голомт Банк	Ерөнхийлөгч	2015 - 2016
4	Мандал Даатгал ХК	Үүсгэн байгуулагч, Ерөнхий захирал	2011 - 2015
5	Тэнгэр Даатгал ХХК	Гүйцэтгэх захирал	2008 – 2011
6	Улаанбаатар хотын банк	Дэд захирал	2006 - 2008
7	Худалдаа хөгжлийн банк	Дилер	2002 - 2006

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Шаравпэлжээ ГАНТУЯА

Төрсөн он: **1982**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Жорж Вашингтон Их Сургууль	АНУ	2007	2008	Олон улсын бизнес удирдлага
2	Хүмүүнлэгийн Ухааны Их Сургууль	Улаанбаатар	1999	2003	Япон хэлний орчуулагч
3	Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль	Улаанбаатар	1998	2002	Бизнес удирдлага

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	2020/09	2020/09	Компанийн засаглал

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилсан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилсан хугацаа
1	“Юу Эм Си Холдинг” ХХК	Үйл ажиллагаа хариуцсан захирал	2013 - одоо
2	“Монгол Ньюс” ХХК	Маркетингийн хэлтсийн захирал	2008 - 2011
3	“Улаанбаатар зочид буудал” ХХК	Маркетингийн албаны дарга	2003 - 2007

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи	Сайн	Сайн	Сайн	Сайн
2	Япон	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Очирпүрэв ГАНЖОЛОО

Төрсөн он: **1977**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Берлин хотын Чөлөөт Их Сургууль	ХБНГУ	1997	2002	Эдийн засгийн магистр

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	2014/11	2014/11	Компанийн засаглал

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Голомт Файнэншил Групп ХХК	Гүйцэтгэх захирал	2014 - одоо
2	Бодь Интернэшнл ХХК	Санхүү удирдлагын газрын захирал	2011 - одоо

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн
2	Герман хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Отгон МӨНХЖАРГАЛ

Төрсөн он: **1982**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Бэнтлигийн Их Сургууль	АНУ	1999	2003	Санхүүгийн шинжлэх ухааны бакалавр

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Банк Санхүүгийн Академи	2018/02	2018/02	Компанийн засаглал

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Голомт Капитал ҮЦК ХХК	Гүйцэтгэх захирал	2017 - одоо
1	Спейшлайзд Карьер Консалтинг ХХК	Санхүү эрхэлсэн захирал	2015 - 2017
1	Баян айраг ХХК	Санхүүгийн менежер	2012 - 2015
2	Централ эшиа Майнинг саффлая ХХК	Санхүү эрхэлсэн захирал	2008 - 2012

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Лувсанжамба ГАНЗОРИГТ

Төрсөн он: **1962**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Ленинградын Кино Инженерийн Дээд Сургууль	ОХУ	1981	1986	Цахилгааны инженер

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв			Компанийн засаглал

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Бадарлан ХХК	Ерөнхий захирал	2010 - одоо
2	Монложистик Ворлдвайд ХХК	Санхүүгийн захирал, ТУЗ-ийн дарга	2005 - одоо
3	Наран Тээг ХХК	Гүйцэтгэх захирал	2017 - 2019

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн
2	Орос хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Батсайхан ЖАВХЛАН

Төрсөн он: **1984**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ШУТИС - КТМС	Улаанбаатар	2000	2004	Программ хангамж

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Мандал Даатгал ХК	Гүйцэтгэх захирал	2016 - одоо
2	Мандал Даатгал ХК	Бизнес хөгжил хариуцсан дэд өрөнхийлөгч Иргэдийн даатгал хариуцсан дэд өрөнхийлөгч	2011 - 2016
3	Дижимо ХХК	Систем инженер	2007 - 2010
4	Оранжсофт технологи ХХК	Програмист	2005 - 2007
5	Ай Эс Си Монгол ХХК	Програмист	2004 - 2005

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн
2	Япон хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД

1. **Жэймс Бернард Двайер**
2. **Жамсрандорж овогтой Дэлгэрсайхан**
3. **Эрдэнэбат овогтой Нандинзүрх**
4. **Гарамдорж овогтой Гантулга**

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Жэймс Бернард Двайер

Төрсөн он: **1943**

Төрсөн газар: **АНУ**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	Columbia Graduate School of Business	АНУ	1968	1970	Бизнесийн удирдлагын магистр
2	University of Notre Dame	АНУ	1961	1965	Бизнесийн удирдлагын бакалавр

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	2018/08	2018/08	Компанийн засаглал

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	Голомт Банк	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2018 - одоо
2	Mongolia Mutual Finance Group	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2017 - одоо
3	Mongolia Growth Group	ТУЗ-ийн хараат бус гишүүн	2014 - одоо
4	Mongoljin Private Capital Ltd	Ерөнхий захирал	2013 - одоо
5	Монголын Бизнес Зөвлөл	Гүйцэтгэх захирал	2007 - 2016
6	NAMBC-Mongolia	Үйл ажиллагаа хариуцсан захирал	2003 - 2007
7	Bearing Point (KPMG консалтинг)	Хөрөнгө оруулалтын банкны зөвлөх	2001 - 2003

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Жамсрандорж ДЭЛГЭРСАЙХАН

Төрсөн он: **1974**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ХААИС - ЭЗСургууль	Улаанбаатар	1992	1995	Эдийн засаг
2	МУИС - ХЗС	Улаанбаатар	2004	2006	Эрх зүй
3	СЭЗИС	Улаанбаатар	2000	2003	Санхүүгийн удирдлагын магистр

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Санхүүгийн академи	2012/10	2012/11	Компанийн засаглал
2	ОУ-ын санхүүгийн корпораци	2012/05	2012/05	
3	МҮИИнститут	2012/11	2012/12	Хөрөнгийн үнэлгээ

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	СЭЗИС	Багш	1996 - одоо

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Дунд	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Эрдэнэбат НАНДИНЗҮРХ

Төрсөн он: **1976**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	МУИС-ОУХДС	Улаанбаатар	1994	1998	Дипломатч, баклавр

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Компанийн засаглалын хөгжлийн төв	2021/03	2021/03	Компанийн засаглал
2	Флорида, АНУ	1997	1997	Зочид буудлын менежмент Зочид буудлын менежмент

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	СИРМ ХХК	Ерөнхий захирал	2004 - одоо
2	ЭМОН ХХК	Захирал	2013 - одоо
3	Монголын Боулинг холбоо	Ерөнхийлөгч	2010 - одоо

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД



Гарамдорж ГАНТУЛГА

Төрсөн он: **1976**

Төрсөн газар: **Улаанбаатар хот**

БОЛОВСРОЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Төгссөн сургууль	Байршил	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил
1	ХУДС	Улаанбаатар	1998	2002	Нягтлан бодогч
2	ХУДС	Улаанбаатар	2002	2004	Бизнесийн удирдлага
3	СЭЗИС	Улаанбаатар	2015	2018	Бизнес удирдлага

МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ, МЭРГЭШЛИЙН БЭЛТГЭЛ

№	Сургууль, дамжаа, курс	Элссэн огноо	Төгссөн огноо	Чиглэл
1	Төслийн санхүүжилт, Улаанбаатар, Монгол улс, "Цэцэнбилгүүн консалтинг" ХХК	2018	2018	Төслийн санхүүжилт
2	Зөвлөхийн үндсэн ур чадварыг хөгжүүлэх сургалт, Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт ТББ	2013	2013	Менежментийн Зөвлөх
2	АССА (ОУ-ын мэргэшсэн нягтлан бодогчдын нийгэмлэг)	2008	2013	АССА part II
2	Хөрөнгийн үнэлгээний сургалт, Монголын Хөрөнгийн Үнэлгээчдийн Нийгэмлэг	2010	2010	Хөрөнгийн үнэлгээ
2	Корпорацийн засаглалын шинжээч, сургагч багш бэлтгэх сургалт, Монголын Корпорацийн Засаглалын Хөгжлийн Төв	2009	2009	Монголын Корпорацийн Засаглалын Хөгжлийн Төв
2	АССА (ОУ-ын мэргэшсэн нягтлан бодогчдын нийгэмлэг)	2006	2008	Certified Accounting Technician
2	Монголын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Институт	2004	2004	Монголын мэргэшсэн нягтлан бодогч

АЖИЛ ЭРХЛЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№	Ажилласан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
1	СЭЗИС	ОУНББСМС-ийн захирал	2020 - одоо
2	ЭМОН ХХК	Багш, Тэнхмийн эрхлэгч	2005 - 2020
3	ХУДС	Багш	2002 - 2005

ГАДААД ХЭЛНИЙ МЭДЛЭГ

№	Гадаад хэл	Сонсох	Ярих	Унших	Бичих
1	Англи хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн
2	Орос хэл	Сайн	Сайн	Сайн	Сайн

КОМПАНИЙН ДҮРМИЙН НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

КД	КД Компанийн дүрмийн 7.8-р заалт
7.8	Дараах асуудлууд нь зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар шийдвэрлэнэ:
КД	Компанийн дүрмийн 7.8.1-р зүйлд дараах өөрчлөлтийг оруулах
7.8.1 хуучин	ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох;
7.8.1 шинэ	ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас өмнө дуусгавар болгох, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг тогтоох;
КД	Компанийн дүрмийн 8.13-р заалт
8.13	ТУЗ нь Компанийн тухай хууль болон энэ дүрмээр хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамааруулснаас бусад дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
КД	Компанийн дүрмийн 8.13.15-р зүйлийг хасах:
8.13.15	ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллыг тогтоох;
